

АВТО ЗАМЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Авто зам, замын байгууламжийн бэлэн байдлын түвшин, аюулгүй байдлыг хангах, авто замын сангийн орлого, хөрөнгийн зарцуулалтад тавих олон нийтийн хяналтын оролцоог хэрэгжүүлэх Авто замын зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Зөвлөл нь авто зам, замын байгууламжийн бэлэн байдлын түвшин, аюулгүй байдлыг хангах бодлого болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, авто замын сангийн хөрөнгө төвлөрүүлэлт, зарцуулалтад хяналт тавих дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус бүтэцтэй байна.

1.3. Зөвлөл нь Авто замын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

1.4. Зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд гаргасан дүгнэлт, зөвлөмжийг авто зам, замын байгууламжийг өмчлөгч, эзэмшигч, хариуцагч байгууллагууд биелүүлэх үүрэгтэй.

Хоёр. Зөвлөлийн чиг үүрэг

2.1. Зөвлөл нь авто зам, замын байгууламжийн бэлэн байдлын түвшин, аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийн бэлэн байдлын түвшин, аюулгүй байдлыг хангах зорилгоор жил бүрийн засвар арчлалтын төлөвлөгөөний төслийг хянан дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж авто зам эзэмшигчид хүргэх;

2.1.2. Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын ажлын явц байдал, чанарт хөндлөнгийн хяналт тавьж зөвлөмж гаргах;

2.1.3. Авто зам, замын байгууламжийн бэлэн байдал, аюулгүй байдлын түвшинг хэрхэн хангаж байгаа талаар дүгнэлт зөвлөмж гаргах;

2.2. Зөвлөл нь олон нийтийн оролцоог хангах зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1. Авто замын сангийн хөрөнгө төвлөрүүлэлт зарцуулалтад хяналт тавьж дүгнэлт, зөвлөмж гаргаж авто зам өмчлөгч, эзэмшигчид хүргэх;

2.2.2. Авто замын сангийн хөрөнгийн эх үүсвэрийн орлогын төлөвлөгөө түүний хэрэгжилттэй танилцаж зөвлөмж гаргах;

2.2.3. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавих, дүгнэлт зөвлөмж гаргах;

Гурав. Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн

3.1. Авто замын сангийн төлөвлөлт, зарцуулалт ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байж авто зам, замын байгууламжийн бэлэн болон аюулгүй байдлыг хангахад олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх үндсэн үүрэг бүхий Авто замын зөвлөл нь

зам хэрэглэгчид, төрийн бус байгууллага, авто зам эзэмшигч, хариуцагч болон иргэдийн төлөөллөөс бүрдсэн 9 гишүүний /цаашид “Зөвлөлийн гишүүд” гэх/ бүрэлдэхүүнтэй байна.

3.2. Зөвлөлийн гишүүд нь орон тооны бус байна.

3.3. Зөвлөлийн дарга, гишүүдийг холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 3 жилийн хугацаагаар томилно.

3.4. Зөвлөлийн гишүүдийг дараах тохиолдолд чөлөөлнө:

- 3.4.1. эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн,
- 3.4.2. чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;
- 3.4.3. үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн;
- 3.4.4. гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон;
- 3.4.5. ашиг сонирхлын зөрчил үүссэн;
- 3.4.6. бусад.

3.4. Зөвлөлийн гишүүд нь хугацаанаасаа өмнө үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд түүнийг нөхөн томилно.

Дөрөв. Зөвлөлийн эрх, үүрэг

4.1. Зөвлөл дарга дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

- 4.1.1.Хурал даргалах,
- 4.1.2.Зөвлөлөөс гаргасан дүгнэлт, зөвлөмжийг албажуулан холбогдох байгуулагад хүргэх,
- 4.1.3. Дүгнэлт, зөвлөлжийн хэрэгжилт, хариуг шаардах,
- 4.1.4. Зөвлөлийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлага чиглэлээр хангах,
- 4.1.5. Зөвлөлийн гишүүдийг хяналт, шалгалт, зөвлөмж, дүгнэлт гаргах ажилд томилох,
- 4.1.6 Зөвлөлийн байнгын үйл ажиллагаатай холбоотой бусад ажил,

4.2 Зөвлөлийн гишүүд нь дараах эрхтэй байна. Үүнд:

- 4.2.1.Зөвлөлийн хуралд оролцох,
- 4.2.2.Зөвлөлийн хурлаар хэлэлцэх аливаа танилцуулга, мэдээллийг гаргуулан авах,
- 4.2.3. Зөвлөлийн хурлын тэмдэглэлтэй танилцах
- 4.2.4. Зөвлөлөөс гаргах дүгнэлт, зөвлөмжид санал өгөх

4.3. Зөвлөлийн гишүүд нь дараах үүрэгтэй байна. Үүнд:

- 4.3.1.Зөвлөлийн хуралд оролцож, хэлэлцэж буй аливаа асуудалд хариуцлагатай хандах
- 4.3.2. Гишүүд нь хуралд оролцохдоо хэлэлцэх асуудлыг урьдчилан нарийн судалж өөрийн саналыг бэлтгэж ирэх.
- 4.3.3. Зөвлөлийн үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэхдээ хувь хүний байр сууринаас хандахгүй бөгөөд зөвхөн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэх

Тав. Зөвлөлийн зардал

5.1. Зөвлөлийн гишүүдэд тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлснийх нь төлөө ажлын хөлс /цалин/ олгоно.

5.2. Зөвлөлийн гишүүдын ажлын хөлс /цалин/, үйл ажиллагааны зардлыг Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана.

5.3. Зөвлөлийн зардлыг Авто замын сангаас санхүүжүүлнэ.

Зургаа. Зөвлөлийн үйл ажиллагаа

6.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь авто замын засвар, арчлалтын ажил, Авто замын сангийн орлого, зарлагын байдалтай танилцаж хяналт тавьж, дүгнэлт зөвлөмж гаргах үйл ажиллагаа байна.

6.2. Зөвлөлийн дүгнэлт, зөвлөмж нь зөвлөлийн хурлаар /цаашид “хурал” гэх/ хэлэлцэгдэж олонхийн саналаар дэмжигдсэний үндсэн дээр гарна.

6.3 Хурлыг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулах бөгөөд хурлын товыг зөвлөлийн дарга гаргана.

6.4. Хурлыг зөвлөлийн дарга удирдах бөгөөд түүний эзгүйд зөвлөлийн нарийн бичгийн дарга хурлыг удирдан явуулна.

6.5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг зөвлөлийн дарга батлана.

6.6. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцуулга, холбогдох мэдээллийг хурал эхлэхээс ажлын 5 хоногийн өмнө зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.

6.7. Зөвлөлийн ээлжит бус хурлыг зөвлөлийн дарга эсхүл гишүүдийн олонхийн саналыг үндэслэн зохион байгуулж болно.

6.8. Хурал нь 5 буюу түүнээс дээш гишүүд оролцсоноор хүчин төгөлдөр болно.

6.9. Хурлын тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хариуцан хөтлөх бөгөөд тэмдэглэлд нийт хуралд оролцогчид гарын үсэг зурснаар баталгаажна. Хурлын тэмдэглэлд тухайн хурлаар хэлэлцсэн асуудлын жагсаалт, холбогдох материалыг хавсаргасан байна.

6.10. Зөвлөл нь өөрийн тэмдэгтэй байна.

6.11. Зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас /бланк/-тай байна.

6.12. Хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжид зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

6.13. Хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг ажлын 5 хоногийн дотор холбогдох байгууллагад хүргүүлнэ.

6.14. Хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагууд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй байдалд хяналт тавина.

Долоо. Зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаанд хориглох зүйл

7.1. Аливаа улс төр, бизнесийн бүлэглэлийн ашиг сонирхлыг төлөөлөх.

7.2. Зөвлөлөөс гаргасан албажаагүй дүгнэлт, зөвлөмжийг өөрийн болон бусдын эрх ашигт нийцүүлэн урвуулан ашиглах, олон нийтэд задруулах.

Найм. Хариуцлага

8.1. Зөвлөлийн гишүүн тус журмын 7.1-7.2 дахь заалтыг зөрчсөн нь тогтоогдвол, зөвлөлийн гишүүнээс чөлөөлж, зохих хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээр холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.